

Ард Санхүүгийн Нэгдэл ХК

MSE: **ARD**

**2024 оны хагас жилийн тайлан**

Хүчтэй. Хамтдаа.





## Б.Золбоо

Гүйцэтгэх Захирал

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ,

Юун түрүүнд та бүгддээ Үндэсний их баяр наадмын халуун мэндийг хүргэе. Монгол Улсад Тулгар төр байгуулагдсаны 2233 жилийн ой, Их Монгол Улс байгуулагдсаны 818 жилийн ой, Ардын хувьсгалын 103 жилийн ой энэ онд тохиож байна. Энэ зэрэгцээ 2010 оноос эхлэн 11 дэх удаагаа зохион байгуулагдаж буй Монголын Эдийн Засгийн Чуулган 7 сарын 7-9-ний өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө. Ардын баг хамт олон Чуулганы зохион байгуулалтад жил бүр сайн дураар оролцоотой ажиллаж ирсэн нь Хүчтэй. Хамтдаа. уриатай бидний хувьд эх орныхоо нийгэм, эдийн засаг, онцлог давуу талыг дотооддоо төдийгүй олон улсад түгээхэд хувь нэмрээ оруулах чин хүсэлтэй иргэний үүрэг хэмээн хардаг билээ. Энэ жил Go Mongolia уриатай зохион байгуулагдсан тус чуулганд 4,100 гаруй хүн оролцож, Засгийн Газрын бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцүүлэн нийгэм, эдийн засгийн асуудлуудыг хэлэлцэв. Мөн чуулганы хүрээнд зохион байгуулагдсан MEF Youth болон Central Asia Tech Summit-ыг 1,500 гаруй залуус, дотоодын болон гадаадын олон тооны гарааны бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид зорин ирлээ. Уг үйл явдалтай зэрэгцэн шинэ Засгийн Газрын бүтэц бүрэлдэхүүн батлагдаж, Ерөнхий Сайд дахин сонгогдож, Монгол Ардын Нам, Ардчилсан Нам, ХҮН намууд хамтарсан Засгийн Газар байгуулж буйгаа зарласан юм. Энэ утгаараа чуулганы хэлэлцүүлгүүд үр өгөөжтэй болж, шинэ Засгийн Газарт үнэ цэнтэй санал, зөвлөмжүүд ирлээ.

Монгол Улсын эдийн засаг 2024 оны эхний улиралд 7.8 хувийн өсөлттэй гарч, 2023 оны жилийн эцсийн 7 хувийн өсөлтийг давж, хүлээлтээс давлаа. Энэхүү өсөлтөд уул уурхайн салбар голлон нөлөөлсөн хэвээр байгаа бөгөөд хагас жилээр нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээ буюу 40.6 сая тоннд хүрсэн байна. Түүнчлэн дотоодын эрэлт, хэрэгцээ нэмэгдэж, өрхийн болон Засгийн Газрын хэрэглээ тэлсэнтэй холбоотойгоор уул уурхайн бус салбарууд өсөлттэй байлаа. Гэвч цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хумигдаж байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв сайжирч байгаа ч геополитикийн хурцадмал байдал, улс хоорондын зөрчилдөөнтэй холбоотой суурь эрсдэлүүд байсаар байгаа нь ДНБ-ий өсөлтийг Төв банк болон гадаадын байгууллагуудын таамаглаж буй 4-5 хувьд хүртэл бууруулах боломжтой юм. Инфляцын түвшин тасралтгүй буурч буйтай холбоотойгоор Төв банк бодлогын хүүгээ 3 болон 5 сард тус бүр 1 нэгж хувиар бууруулж, 11 хувьд хүргэсэн. Харин дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалах, гадаад, дотоод эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс Төв банк 7 сард бодлогын хүүг хэвээр үлдээх шийдвэр гаргалаа. Энэхүү бодлогын шийдвэр нь инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилттой нийцэж байгаа юм. Түүнчлэн олон улсын зах зээл дэх эрсдэлгүй хүүгийн түвшин болон заавал байлгах гадаад валютын нөөцийн түвшин өндөр байгаагаас шалтгаалан банкнуудын эх үүсвэрийн өртөг өндөр байгаа тул гадаад валютын өр төлбөрт заавал байлгах нөөцийг 18 хувиас 15 хувь болгон бууруулсан байна.

Нэрлэсэн цалин, хэрэглээний зээлийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор Төв банкнаас хэрэглээний зээлийн өр, орлогын дээд хязгаарыг 60 хувиас 55 хувь болгон бууруулсан нь хэрэглээний зээлийн илүүдэл эрэлтийг бий болгож байна. Монголбанкны энэхүү зохицуулалтын улмаас хэрэглээний зээлийн эрэлт банк бус санхүүгийн байгууллагын зээлийн багцууд руу шилжих нөхцөл үүсэв. Өөрөөр хэлбэл хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг 60 хувиас 55 хувь болгон бууруулсан нь шинэ хэрэглээний зээлийн 1/12 хүртэлх хувь нь банк бус санхүүгийн салбарт шилжих нөхцөлийг бүрдүүлж байгаа юм. Сүүлийн 5 сарын байдлаар шинээр олгосон хэрэглээний зээлийн сарын дундаж хэмжээ 790 тэрбум төгрөг байсан бөгөөд 66 тэрбум төгрөг банк бусын салбарт шилжиж болзошгүй байна. Банкны шалгуурыг харгалзан тус шилжих боломжтой багцын эрсдэл харьцангуй бага гэж үзэхээр байгаа юм.

Төв банкны бодлогын хүүг бууруулах шийдвэрийн дараа Ард Кредит болон Ард Актив нь санхүүжилтийн хүүгээ хугацаанаас хамаарч 1-2 хувиар буурууллаа. Ардын Тэтгэврийн Сан нь мөн тэтгэврийн хуримтлалын өгөөжөө бууруулж, одоо хэрэгжиж буй гэрээнүүдийн хүүг 2 хувиар бууруулан 14 хувьд хүргэсэн бол шинэ гэрээнүүдийн хүүг 11 хувиар тогтоосон. Биржийн бус зах зээлийн хүүг харгалзан үзэж бондын купоны хүү мөн 1 хувиар бууруулсан. Инфляц аажмаар буурч, оны эхний хагас жилийн эцэст 5.1 хувьд хүрсэн. Үүнд Төв банкны мөнгөний хатуу бодлого, худалдааны түнш орнуудын инфляц саармагжсан, тээврийн зардал буурсан, төгрөгийн ханш чангарсан зэрэг хүчин зүйлс нөлөөлөв. 2023 онд үнийн өсөлт өндөр байсан гурил, гурилан бүтээгдэхүүний үнийн өсөлт саарч, махны үнийн бууралт улирлын нөлөөллөөс давж, дотоодын хүнсний инфляцыг бууруулсан. Үнийн савлагаа багатай хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц мөн буурсаар байгаа нь үнийн ерөнхий өсөлтийг сааруулжээ. Нийлүүлэлтийн гаралтай инфляц буурахаас гадна улирлын чанартай холбоотой инфляц ирэх саруудад саарах төлөвтэй байна. Гэвч бодит цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт болон сонгуулийн үеэс хамааран эрэлтийн гаралтай инфляц үүсэх эрсдэлтэй байна.

Жилийн инфляц Төв банкнаас тогтоосон 6±2% хувийн хүссэн интервалд хүрсэн ч оны эхнээс тооцсон инфляц аль хэдийн 4.3 хувьд хүрээд байгаа нь оны эцэст зорилтот түвшнээс давах эрсдэлтэй байгааг харуулж байгаа юм. Төв банкнаас сүүлд бодлогын хүүг 11 хувьд барих шийдвэр гаргасныг үүнтэй холбон тайлбарлаж болохоор байна.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2024 оны 6 сарын эцэст урьдчилсан мэдээллээр 41.4 ихнаяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 10 ихнаяд төгрөг буюу 31.7 хувиар өссөн байна. Энэ өсөлтөд төгрөгийн хадгаламж 5.2 ихнаяд төгрөг буюу 36.2 хувь, төгрөгийн харилцах 3.3 ихнаяд төгрөг буюу 44.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Гэвч долларжилт өндөр хэвээр байгаа бөгөөд гадаад цэвэр актив 9.9 ихнаяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өссөн байна. Зээлийн үлдэгдэл ч мөн адил өсөж байгаа бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн хэмжээ хагас жилийн эцэст 33.5 ихнаяд болж, өмнөх оны мөн үеийнхээс 7.9 ихнаяд буюу 30.9 хувиар өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 58.8 хувь нь иргэдэд, 39.4 хувь нь хувийн байгууллагуудад, 0.7 хувь нь төрийн байгууллагуудад, 1.2 хувь нь санхүүгийн байгууллагууд болон бусад байгууллагуудад ногдож байна. Олгосон зээлийн чанар сайжирч, муу зээл 5.8 хувь болсон байна.

Америк долларын ханш сүүлийн 9 сарын турш буурч, 2024 оны 6 сард дунджаар 3381.11 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 57.16 төгрөгөөр буурсан байна. Харин 2024 оны 3 сар хүртэл өмнөх 16 сарын хугацаанд өсөж байсан гадаад валютын албан нөөц сүүлийн улиралд 5.2 тэрбум америк доллароос 4.8 тэрбум болж буурчээ. II улиралд улсын орлого 14.9 ихнаяд төгрөгт хүрч, өнгөрсөн онтой харьцуулахад 35.2 хувиар өссөн байна. Зарлага, цэвэр зээл 12.9 ихнаяд төгрөгт хүрч, 1.3 ихнаяд төгрөгийн ашигтай гарсан байна. Ашигт малтмалын экспорт болон импорт нэмэгдсэнтэй холбоотой татварын орлого ихэссэн нь тус ашигт голчлон нөлөөлсөн байна. Орлогын албан татвар 67.2 хувиар буюу 1.7 ихнаяд төгрөг, НӨАТ 27.3 хувиар буюу 594.6 тэрбум төгрөг, уул уурхайн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 21.7 хувиар буюу 376.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Хөрөнгийн зах зээлийн идэвхжил нэмэгдэж, эхний хагас жилд 797 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалагдсан бол өнгөрсөн оны мөн үед 513 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалагдсан байна. Гол бүтээгдэхүүн нь Улаанбаатар хотын бонд байснаар 500 тэрбум төгрөгийн арилжааг бүрдүүлэв. Хамгийн чухал нь үнэт цаас болон компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа өнгөрсөн оны мөн үеийнхээс 105 тэрбум төгрөг, 11 тэрбум төгрөг байснаас 161 тэрбум төгрөг, 45 тэрбум төгрөг болж тус тус өссөн байна. Зах зээлийн нийт үнэлгээ эхний хагас жилд 288 тэрбум төгрөг буюу 2.6 хувиар өсөж, 11.3 ихнаяд төгрөгт хүрсэн байна. ТОП-20 индекс дээд цэгтээ 45,024, доод цэгтээ 40,704-ийн хооронд хэлбэлзэж, 44,385 нэгжид хаагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20 хувиар өссөн байна. MSE:AARD-ын хувьцаа нь эхний хагаст хамгийн их арилжаалагдсан 9 дэх хувьцаа болжээ.

Ард Санхүүгийн Нэгдэл нь II улиралд бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтийн ажилд гол анхаарлаа хандуулсан хэвээр байлаа. Түүнчлэн, бид компаниудынхаа 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэл, шинэчлэн батлагдсан OGSM, бизнес төлөвлөгөөг танилцуулах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлуудыг амжилттай зохион байгууллаа. 4 сарын сүүлд бид 1,200 гаруй хувьцаа эзэмшигч, харилцагчид оролцсон хувьцаа эзэмшигчдийн хурлыг Crypto Week:powered by ardcoin нэрийн дор оффис дээрээ 7 хоногийн турш зохион байгуулж, зорин ирсэн харилцагч нартаа сонирхолтой даалгавар биелүүлэн Ардын Эрх цуглуулах боломжийг нээж, компани бүр бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлан таниулсан.

Ард Санхүүгийн Нэгдэл нь II улиралд бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтийн ажилд гол анхаарлаа хандуулсан хэвээр байлаа. Түүнчлэн, бид компаниудынхаа 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэл, шинэчлэн батлагдсан OGSM, бизнес төлөвлөгөөг танилцуулах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлуудыг амжилттай зохион байгууллаа. 4 сарын сүүлд бид 1,200 гаруй хувьцаа эзэмшигч, харилцагчид оролцсон хувьцаа эзэмшигчдийн хурлыг Crypto Week:powered by ardcoin нэрийн дор оффис дээрээ 7 хоногийн турш зохион байгуулж, зорин ирсэн харилцагч нартаа сонирхолтой даалгавар биелүүлэн Ардын Эрх цуглуулах боломжийг нээж, компани бүр бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлан таниулсан.

Өнгөрсөн жилийн эцэст санхүүгийн бус компаниуд болох Грэйпсити Монгол ХХК, Даац Инвестмент ХХК (Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК-ийн толгой компани), Крипто Үндэстэн болон ТэнГэрЛиг Медиа Группыг Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Хөвсгөл ХК-д шилжүүлсэн. УБҮЦБ-ийн хувьцаа эзэмшигчид өрийг хувьцаагаар солих болон ГрэйпСитигийн төлбөр тооцооны төвийн системийг шинэ хувьцаагаар төлөх зэрэг өмчийн өөрчлөлтийн бүртгэлийг зөвшөөрсөн. Үүний үр дүнд эцсийн өмчлөлөөр Ард Санхүүгийн Нэгдэл нь 48.5 хувийн эзэмшилтэй болох бөгөөд ГрэйпСити Монгол ХХК-ийн 2.7 хувийн эзэмшилтэй нийлээд нийт 51.3 хувийг эзэмших болж байна. 4 сарын сүүлээр Хөвсгөл ХК-ийн ээлжит хурлаар Даац Инвестмент компанийг эс тооцвол бусад шилжүүлсэн компаниудыг худалдан авахад үүсээд байсан авлагыг барагдуулах зорилгоор шинээр хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд компанийн нэрийг AIG болгон өөрчилсөн.

Өндөрхаан ХК нь даатгал болон тэтгэврийн сангийн холдинг компани бөгөөд бүтцийн өөрчлөлт хийж байна. Ард Даатгал ХК-ийг 2024 оны II хагас жилд шилжүүлэхээр төлөвлөснийг 6 сард ТУЗ-өөс баталсан. Ингэснээр бид стратегийн хөрөнгө оруулагчдыг татах эсвэл одоо байгаа даатгалын компаниудыг нэгтгэх замаар амьдралын даатгалын компани байгуулах боломжтой гэж дүгнэж байна.

Ард Кредит нь нийт 13.5 тэрбум төгрөгийн нээлттэй бонд гаргах хүсэлт өгсөн бөгөөд саяхан гаргасан олон нийтэд санал болгосон нэмэлт хувьцаагаа арилжаалан өөрийн хөрөнгөө 8.9 тэрбум төгрөгөөр өсгөсөн. Энэхүү санал болгосон хувьцаа нь компанийн хувьцааны тоог FPO-ийн өмнөх байдлаар 30 хувь, FPO-ийн дараах байдлаар 23 хувиар нэмэгдүүлсэн. II улирлын эцсийн байдлаар Ард Кредитийн нийт хөрөнгийн хэмжээ 83.7 тэрбум төгрөгт хүрч, төсөвлөсөн хэмжээний 91 хувийг хангасан байна. Энэ нь оны эхнээс 11.7 тэрбум төгрөг буюу 16 хувиар, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20.7 тэрбум төгрөг буюу 33 хувиар өссөн үзүүлэлт юм. Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос ББСБ-уудын багц дахь ногоон зээлийн эзлэх хувь дээр үндэслэн итгэлцлийн санхүүжилтийн харьцааг өөрийн хөрөнгийн 80 хувиас 100 хувь болгон нэмэгдүүлсэн шинэ журмын дагуу компани нь эко, ногоон бүтээгдэхүүний санхүүжилт олгож эхэллээ. Ард Кредитийн зээлийн багц оны эхний хагаст 4.9 тэрбум төгрөг буюу 10 хувиар өсөж, 53 тэрбум төгрөгт хүрчээ. Тус баг багцын чанарыг үр дүнтэй сайжруулж, эрсдэлтэй багц (PAR) болон чанаргүй зээлийг (NPL) 11.8 хувь болон 7.1 хувиас, 9.0 хувь болон 5.3 хувь болгон тус тус бууруулж чадсан. Мөн компанийн ашиг 1.5 тэрбум төгрөг болж, төсөвт тусгагдсан хэмжээнээс 181 хувиар давж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 54 хувиар өссөн байна. Кредит скоринг модель нь ARDX-ийг хүчин зүйл болгосноор идэвхтэй, үнэнч харилцагч нар бага хүүтэй, илүү урт хугацаатай зээл авах боломжтой болсон.

Ард Активын нийт хөрөнгө 50.8 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 15.4 хувиар, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 45.4 хувиар өссөн байна. Зээлийн багц 41.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 48.4 хувиар өссөн бол хадгаламжийн нийт хэмжээ 38.8 тэрбум төгрөг болсон байна. Компанийн цэвэр ашиг 2024 оны эхний хагас жилд 333 сая төгрөг байна.

Ард Лизинг компанийн шинээр томилогдсон Гүйцэтгэх Захирал Д.Мөнх-Од нь Ард Кредитийг байгуулагдсан цагаас эхлэн ажиллаж ирсэн бөгөөд Өсдөг Машин хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. Түүний удирдлагаар тус компани 1.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий AARD хувьцаа болон ARDX-ийг 5 жилийн хугацаатай, 5 хувийн урьдчилгаа төлбөрийн нөхцөлтэйгөөр худалдсан байна. Бид сар бүр 2 тэрбум төгрөгийн багц гаргаж, урьдчилгаа төлбөрөөс гадна сар бүр нэмэлт 42.6 сая төгрөгийн эргэн төлөлтийн орлого бүрдүүлэхээр зорьж байна. Компани борлуулалтын нөөцөө хадгалахын тулд эдгээр хувьцаа, урамшууллын оноог зах зээлээс худалдаж авах шаардлагатай тул энэхүү санаачилга нь AARD болон ARDX-ийн ханшид эергээр нөлөөлнө гэж таамаглаж байна. Нэмж дурдахад бид Түмэн Ард болон Монгол шуудан, Ард Даатгалын хөдөө орон нутгийн салбаруудыг ашиглан борлуулалтын хүч нөөцөө өргөжүүлж байна.

Ард Даатгалын Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах гэр бүлийн хамт гадаад руу нүүхээр төлөвлөж буй тул II улиралд ажлаасаа чөлөөлөгдсөн. ТУЗ түүний хүсэлтийг хүлээн авч, Гүйцэтгэх Захирлаар Ард Даатгалд сүүлийн 13 жил ажилласан, өмнө нь борлуулалт хариуцсан захирлаар ажиллаж ирсэн Н.Эрдэнэтулгыг томилсноор цаашид компанийг манлайлж, урагш ахиулна. Урьдчилсан дүнгээр тус компани 21 тэрбум төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлж, өмнөх оны мөн үеэс 7.7 тэрбум төгрөг буюу 46.9 хувиар өссөн байна. Нөхөн төлбөрийн хэмжээ 10 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин өссөн үзүүлэлт юм. Нэмж дурдахад тус компани дэлхийн давхар даатгагчдад харагдах байдлыг нэмэгдүүлэхийн тулд анхны тогтвортой байдлын тайлангаа гаргалаа. Ардын Тэтгэврийн Сан нь 141,000 гаруй хэрэглэгчийн тэтгэврийн хуримтлалыг удирддаг бөгөөд үүнд 120 компанийн 2,300 гаруй ажилтны тэтгэврийн хуримтлал багтдаг. 2024 оны эхний хагас жилд компанийн тэтгэврийн хуримтлал 5.2 тэрбум төгрөгт хүрч, төсөвлөсөн хэмжээг 101 хувиар биелүүлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 хувиар өссөн байна. Гэхдээ дансны хаалт 623 сая төгрөгт хүрч, төсөвлөсөн хэмжээнээс 186 хувиар давж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 77 хувиар өссөн байна. Үүний үр дүнд цэвэр урсгал 4.1 тэрбум төгрөгт хүрч, төсөвлөсөн хэмжээнээс 89 хувийг биелүүлж, өнгөрсөн онтой харьцуулахад тогтвортой хэвээр байна.

Ард Секюритиз нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан нь нүүрс, төмрийн хүдэр, зэсийн борлуулалтын худалдан авах, нийлүүлэх тал дээр зуучлах боломжийг бий болголоо. Монголын Эдийн Засгийн Чуулганы үеэр тус компани Сингапурын гарааны компанитай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, хиймэл оюун ухаанд суурилсан баялгийн менежментийн шийдлийг санал болгож, Ард Апп хэрэглэгчдэд эрсдэл даах чадвар болон хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарсан зохистой хөрөнгө оруулалтын багцыг олон улсын биржээс төрөл бүрийн үнэт цаасаар бүрдүүлэх боломжийг нээж байна. Мөн энэхүү шийдэл нь хувьцааны талаарх мэдээ, судалгааг автоматаар гаргах юм. Эхний хагас жилийн байдлаар тус компани 31 тэрбум төгрөгийн үнэт цаасны зуучлалын үйл ажиллагаа явуулсны 10 тэрбум төгрөг нь Ард Аппаар дамжин хийгджээ.

Мөн тус компани энэ хугацаанд 21 тэрбум төгрөгийн бонд босгосон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зуучлалын болон хөрөнгө босгох үйл ажиллагаа тогтвортой байна.

Ард Менежментийн Гүйцэтгэх Захирал Ч.Хандаа нь гадаадад суралцахтай холбоотойгоор ажлаа хүлээлгэн өгсөн бөгөөд Ард Секюритиз компанид арилжааны дилерээр ажлын замналаа эхэлсэн, сүүлийн 3 жилд хөрөнгө оруулалтын сангийн менежерээр ажилласан Ч.Даваасамбуу Ард Менежментийн шинэ Гүйцэтгэх Захирлаар томилогдов. Ард Менежмент нь нийт 8.2 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй 2 хөрөнгө оруулалтын санг удирддаг бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тогтвортой байна.


Ард Пропертиз нь Блью Скай Тауэрын 9 давхарт байрлах үл хөдлөх хөрөнгийг токенжуулсан BS9 төслийг удирдаж, токен эзэмшигчдэдээ сар бүр түрээсийн орлого хуваарилахын зэрэгцээ 11 давхарт байрлах оффисын зориулалттай объектыг үйлчлүүлэгчдийн өмнөөс удирддаг. Компани цаашид үйл ажиллагааны хүрээгээ өргөжүүлэх зорилгоор бусад үл хөдлөх хөрөнгийг токенжуулах төслүүдийг хайж байна.

Бид Ард Аппын V хувилбарыг хөгжүүлсээр байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын цэсийг шинэчлэн нэвтрүүлсэн. Гол өөрчлөлт нь Ухаалаг Хөрөнгө Оруулагч бүтээгдэхүүн бөгөөд хэрэглэгчид өөрсдийн болон хүүхдийн дансанд хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг автоматаар худалдан авах боломжийг нээв. Үүний үр дүнд 650 хэрэглэгч Ухаалаг Хөрөнгө Оруулагч бүтээгдэхүүнд бүртгүүлсэн бөгөөд бид 10,000 хэрэглэгчид хүргэх зорилготой томоохон маркетингийн кампанит ажил эхлүүлэхээр төлөвлөж байна. Мөн Pick n Pay бүтээгдэхүүний (одоо ав, дараа төл) хөгжүүлэлтүүд ахицтай байж, кредит скоринг болон хэрэглэгчдэд хялбар, ээлтэй байдлыг улам сайжрууллаа. Үүний зэрэгцээ бид мерчантад зориулсан iBank платформыг шинэчилж, өөрсдөө зайнаас бүртгүүлэх зэрэг шинэ функцуудыг нэвтрүүлж байна. III улирлын эхээр бид Ард Аппын V хувилбарыг дуусгаж, хэрэглэгчдэд банкны картаа Ард Апптай холбох боломжийг олгох Card Inside функцыг нэвтрүүлэх болно. Мөн шинэ хадгаламжийн модуль нэвтрүүлж, хэрэглэгчид өөрсдийн хүссэн хугацаагаар хадгаламжийн бүтээгдэхүүнийг үүсгэх боломжтой болох юм.

Түмэн Ард хөтөлбөр нь өнгөрсөн оны сүүлээр эхэлсэн бөгөөд энэ оны эхний хагас жилд 5,261 идэвхтэй гишүүдийг бүртгэсэн. Эдгээр гишүүд нь манай апп, бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан өөрсдийн сүлжээгээ өргөжүүлэх бөгөөд манай экосистемээр дамжуулан санхүүгийн сайн зуршлуудыг төлөвшүүлэхэд нь урамшуулах юм. Гишүүд сард 1,000 Ардын Эрх цуглуулах зорилготой бөгөөд цуглуулж дуусаад 1,000 ардкoйн болгон хувиргах боломжтой юм. Түмэн Ард хөтөлбөрөөр манай бүтээгдэхүүний борлуулалт эхний хагас жилд 2.75 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд ардкoйноор олгосон урамшуулал 3.4 хувийг эзэлж байна. Компаниуд үйл ажиллагаагаа өргөжүүлж,менежментийн өөрчлөлтүүдийн хажуугаар 2 дүнгээ сайжруулж байна. Цаашид бид урьд өмнө идэвхгүй байсан хэрэглэгчийн баазыг идэвхжүүлэх, бүтээгдэхүүний санал болголтыг оновчтой болгож, шинэ боломжуудыг ашиглан зах зээлд байр сууриа бэхжүүлэхэд анхаарна. Бидний өмнө тулгарч буй сорилт, боломжуудыг даван туулахад та бүхний дэмжлэг чухал тул Хүчтэй бөгөөд Хамтдаа байлцана гэдэгт эргэлзэхгүй байна.

Хүчтэй. Хамтдаа.

# Нэгтгэсэн **ТООН ҮЗҮҮЛЭЛТ**




Нийт компани




Нийт ажиллагсад




Хувьцаа эзэмшигч



Ард апп хэрэглэгч




АрдКидс апп  
хэрэглэгч



Ардкойн  
эзэмшигч



Зээлийн данс  
(идэвхтэй)



Даатгуулагч  
(идэвхтэй)




Тэтгэврийн  
хуримтлал эзэмшигч



Үнэт цаасны данс  
эзэмшигч



Ард Актив ХЗХ-ны  
гишүүн



Тусгай зөвшөөрөл

2024 оны 6 сарын 30-ны байдлаар, оны эхнээс


Хүчтэй. Хамтдаа.

# Хөрөнгө оруулалтын багц

## АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

### БАНК


#### ББСБ



#### Лизинг




#### ХЗХ




### ДААТГАЛ


#### Өндөрхаан ХК



#### Ердийн даатгал



#### Тэтгэврийн сан



### ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК


#### ХОМК




#### Хаалттай сан



#### Нээлттэй сан



#### ҮЦК



#### Үл хөдлөх



### ДЭД БҮТЭЦ

#### Шуудан



#### Төлбөрийн платформ



## ХӨВСГӨЛ

### Хөвсгөл ХК




#### Медиа нэгдэл




#### Блокчэйн



#### Үнэт цаасны бирж



#### Програм хангамж




- МХБ дээр нээлттэй компани
- Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшил
- Холбоотой этгээдийн эзэмшил

2024 оны 6 сарын 30-ны байдлаар

# Онцлох хэлцэл - Хөвсгөл



# Онцлох хэлцэл - ӨндөрХаан




# CRYPTO WEEK

powered by  ardcoin



Crypto Week арга хэмжээг 4 сарын 22-27-ний өдрүүдэд Сэнтрал Тауэр дахь **Ардын оффист** амжилттай зохион байгуулав.



Бүртгэлийн QR уншуулсан **харилцагч** 1,196

Нийт **ХЭХ** оролцогчид 623 **ХЭХ** 9


Шууд **дамжуулалт** 15 **ТВ** ярилцлага 11



# Онцлох үйл явдал



6 сарын 3-7-ны өдрүүдэд **Хөвсгөл, Булган, Дархан, Сэлэнгэ, Эрдэнэтэд** суугаа харилцагчидтайгаа ээлжит уулзалтуудаа хийв.



Шинэчлэн загварчилсан харилцагчдад үйлчлэх төв **Сэнтрал Тауэрын 1 давхарт** үүд хаалгаа нээв.

# Онцлох үйл явдал

Тогтвортой хөгжил бол хүрэх цэг бус - Алхах зам!

Ардкойн 5 жилийн ой



**30 ДААТГАЛ**  
ЖИЛ 1994 онд байгуулагдвал

**Тогтвортой хөгжлийн тайлан**  
Монголын ууган даатгалын байгууллага болох Ард Даатгал ХК нь үүсэн хөгжсөний 30 жилийн ойг тохиолдуулан даатгалын салбарт анх удаа тогтвортой хөгжлийн тайланг бэлтгэн танилцууллаа.  
Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зорилгыг дэмжих ажлын хүрээнд үерийн хохиролд ₮1 тэрбум, зуд, цасан шуурганы эсрэг хамгаалалтад ₮449 саяын нөхөн төлбөрийг тус тус олгожээ. Түүнчлэн тэд цахим даатгалыг эрчимжүүлж цаасны хэрэглээгээ 50%-иар бууруулж чаджээ.

Дэлгэрэнгүй тайлан: [www.aic.mn](http://www.aic.mn)

**АРД КРЕДИТ ББСБ**

**Тогтвортой хөгжлийн тайлан**  
Ард Кредит ББСБ ХК нь 2020 оны Үнэт зүйлс, Алсын хараандаа "Нийгэм эдийн засаг, хүрээлэн буй орчны тогтвортой хөгжлийн зорилтуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэгч, улс орон, даян дэлхийн сайн сайхан байдлыг цогцлоход хувь нэмрээ оруулагч нийгмийн хариуцлагатай компани байна" гэж тунхагласан бөгөөд 2023 онд 23.1 тонн цаас буюу 8,470 мод, 74 жил буюу 648,240 цаг, 1,542,857 квт зэргийг тус тус хэмнэжээ.

Дэлгэрэнгүй тайлан: [www.ardcredit.com](http://www.ardcredit.com)



**Ард Даатгал** салбартаа анхлан тогтвортой хөгжлийн тайлан гаргасан бол **Ард Кредит** 2 дахь удаагаа гаргав.

**Ардкойны** 5 жилийн ойг тохиолдуулан ребрендинг хийв. Ардын бүх мерчант харилцагчаа ардкойноор урамшуулдаг болов.

# Ардын Наадам

ARD САНХҮҮГИЙН  
НЭГДЭЛ

ARD | ДААТГАЛ  
SINCE 1994

ARD КРЕДИТ  
ББСБ

ARD АКТИВ  
ХЗХ

ARD БИТ

ҮНДЭСНИЙ  
ХУВЬЧЛАЛЫН  
САН

ARD СЕКЮРИТИЗ  
ҮЦК

ARD ТЭТГЭВРИЙН  
САН

ARD МЕНЕЖМЕНТ  
КОМПАНИ

ARD ЛИЗИНГ  
КОМПАНИ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ  
ҮНДЭСТЭН  
БАЯЛГИЙН САН

idax



**Ардын Наадам** урамшуулалт хөтөлбөр зарлаж, Ард Аппаа ашиглан ардкойн, ардын эрх цуглуулах боломжийг нээснээс гадна Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Ардын Мэдээ сонин тусгай дугаараа хүргэв.

# Улаанбаатар Марафон 2024 x Хүүхдийн баяр



2024.05.25  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
МАРАФОН  
ТАНЫГ ЮУ ХҮЛЭЭЖ БАЙНА ВЭ?

Хүчтэй, Хамтдаа

Саяграл, Тууль, Т.давхарт Ардын салбар  
Төв Цэвэрлэлтийн 2 дугаарт Ардын салбар

Хүчтэй, Хамтдаа

ARD  
Ардын хөрөнгө оруулагчид Алтан шар зөвлөгч Ардын Эргээр нээлтэй

5км 30 Ардын Эрх  
21км 210 Ардын Эрх  
42км 420 Ардын Эрх

Тусам Ард нөмөрлөгч нэгдсэн марафонгийн Ардын Төв 2 дугаарт

Хүчтэй, Хамтдаа

ХӨРӨНГӨ ОРУУЛ

2024.05.25-06.01  
Ардын салбаруудад

Хүчтэй, Хамтдаа

KIDS  
Библийн байж чадна  
Монгол Улсын 0-18 насны хүүхэд бүрийн ирээдүйд хөрөнгө оруулалт багасгаад  
MSE AARD хувиараа 1 саягаар Ардын 1,000 хүүхэд

Хүчтэй, Хамтдаа

ARD  
Хүүхдийн үнэт цаасны данс үнэ төлбөргүй  
БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ  
Төрийн гэрчлэлтэй  
Ардын хөрөнгө оруулагчийн арга зөвлөгчийн  
Хүүхдийн нэг дэргэ ажиллагаа багшны дансны дугаар

2024.05.25-06.01  
Ардын салбаруудад

Хүчтэй, Хамтдаа

ЭХ ҮРСИЙН БАЯРЫН  
УРАМШУУЛАЛ  
2024.05.25-06.01

Хүчтэй, Хамтдаа

KIDS  
АРДКИДСТ ХҮҮХЭД БҮРТГҮҮЛЭЭД  
20 Ардын Эрх  
Хүчтэй, Хамтдаа

KIDS  
Ард Кидс апп-д бүртгүүлсэн хүүхэд бүрт дараах бэлэгтэй  
3 ADT ширхэг хувицаа  
1,000 Ардхойн  
Ирээдүйн Эзэн  
Шинээр хүүхдийн хадгалалт нээсэн тохиолдолд  
1100,000 хадгалалт нээхэд  
300 Ардхойн  
300 Ардын Эрх  
7500,000 хадгалалт нээхэд  
800 Ардхойн  
800 Ардын Эрх  
11,000,000 хадгалалт  
Гарсан бэлэг


ARD  
МЕНЕЖМЕНТ КОМПАНИ  
7500,000 ХОУС нэгж эрх авах  
18 нас хүртэлх хүүхэд ХОУС нэгж эрх авбал 1%-тай тэнцэх Ардхойн  
Хүүхэд үнэт цаасны данс үнэгүй нээх  
Ухаалаг Хөрөнгө Оруулагч шинээр нээхэд  
100 Ардын Эрх  
750,000 ХОУС  
600ш Ардхойн  
1100,000 /ХОУС, МНГУ  
1200ш Ардхойн  
1180,000 /ХОУС, МНР, МОНГУ  
1800ш Ардхойн

Хүчтэй, Хамтдаа

Улаанбаатар Марафон 2024-ыг тохиолдуулан **Хөрөнгө оруулалтын марафон** огтлолцоо аяныг зохион байгуулж, олон нийтийг эрүүл мэнддээ хөрөнгө оруулахыг уриалан км тутамд Ардын Эрхээр урамшуулан баг хамт олноороо марафондов.

АрдКидс аппад бүртгүүлсэн хүүхэд бүрийг урамшуулж, 0-18 насны хүүхдэд **үнэт цаасны данс үнэ төлбөргүй** нээв.


# HOUSE EXPO - 2024



HOUSE EXPO - 2024  
үзэсгэлэнгийн **Дэмжигч**  
байгууллагаар ажиллав.



Шинэ Гэр Түншлэл ХХК-тай  
хамтын ажиллагаагаа **эхлүүлж**,  
санамж бичиг үзэглэв.




Ори Студиос ХХК-тай хамтын  
ажиллагаагаа **өргөжүүлэн**  
**тэлж**, санамж бичиг үзэглэв.

# Онцлох үйл явдал



Ард Кредитын ТУЗ-ийн дарга, idax биржийн Гүйцэтгэх Захирал Ч.Ганзориг **46 дахь удаагийн Dakar Rally**-д амжилттай оролцож, компани төдийгүй эх орныхоо нэр алдрыг олон улсад дуурсгав



Венецын олон улсын **Биеннальд** (La Biennale di Venezia) Монгол Улсаа төлөөлөн оролцсон уран бүтээлчдийг дэмжин ажиллав



Зудын Эрсдэлийг давахад Хамтдаа! уриалгыг түгээж, НОБЕГ-т 21 аймгийн Малчдад хүргэгдэх **300 сая төгрөгийн** уурагт тэжээлийн хандивыг гардуулан өгөв

# Ард Апп

## Хэрэглэгч

1.1 сая

Нийт хэрэглэгч

4.9% ▲

22.1 мянга

Шинэ хэрэглэгч

72.0% ▲

55.8 мянга

АрдКидс хэрэглэгч

27.9% ▲

2.2 сая

Нийт гүйлгээ

397.4% ▲

## Үйлчилгээ

18.0 тэрбум

Хадгаламж

227.3% ▲

44.5 тэрбум

Цахим зээл

181.6% ▲

10.0 тэрбум

Хувьцааны арилжаа

2.0% ▲

235.8 тэрбум

Нийт шилжүүлгийн дүн

168.3% ▲



28.1 сая ширхэг цаас хэмнэж,  
3,249 ширхэг мод хамгаалсан.


2024 оны 6 сарын 30-ны байдлаар, өмнөх оны мөн үеэс

Хүчтэй. Хамтдаа.

# Ард Апп



Ард Апп **5 дахь** хувилбараа хэрэглээнд бүрэн нэвтрүүлэв.





Ард Аппын **Зээл, Хөрөнгө Оруулалтын ЦЭС** шинэчлэгдэв.



Ард Апп хэрэглээг нэмэгдүүлэх **Түмэн Ард** хөтөлбөр хэрэгжиж эхлэн 5,500 гишүүдтэй болов.

# Ард Апп



Ард Аппдаа хүссэн **банкны картаа** холбох боломжтой болно.

Ардын харилцах данс **ДЕБИТ КАРТ**-тай болно.

Харилцагч бүрийн **ОНЦЛОГТ** тохирсон **санхүүгийн үйлчилгээг** санал болгоно.

# Удирдлагын багийн өөрчлөлт



Н.Эрдэнэтулга, Гүйцэтгэх Захирал  
Ард Даатгал

**13 жил**



Г.Сүхбаатар, Гүйцэтгэх Захирал  
Ард Кредит

**8 жил**



Д.Мөнх-Од, Гүйцэтгэх Захирал  
Ард Лизинг

**10 жил**




Ц. Тайшир, Гүйцэтгэх Захирал  
Ардын Тэтгэврийн Сан

**8 жил**

Ардад ажилласан жил

Хүчтэй. Хамтдаа.



# Банкны кластерын гүйцэтгэл



Цахим зээл  
**24/7**



5 минутад  
**₮5 саяыг**



Хиймэл оюун ухаан  
**Кредит  
Скоринг**



Хариултаа  
**Хадгал**

▲ 37.3%  
Нийт хөрөнгө  
**₮134.5 тэрбум**

▲ 33.4%  
Зээлийн багц  
**₮96.1 тэрбум**

▲ 35.6%  
Санхүүжилт  
**₮81.7 тэрбум**

▲ 51.4%  
Цэвэр ашиг  
**₮1.9 тэрбум**



Нийт зээл олголтын дүн  
**₮81.2 тэрбум**

- Бизнес  
**₮26.7 тэрбум**
- Жижиглэн  
**₮9.9 тэрбум**
- Цахим  
**₮44.6 тэрбум**




Нийт зээл олголтын тоо  
**41,253**

- Эмэгтэй  
**56%**
- Эрэгтэй  
**44%**

2024 оны 6 сарын 30-ны байдлаар, өмнөх оны мөн үеэс

Хүчтэй. Хамтдаа.


# Онцлох үйл явдал - Ард Кредит



Монголбанкаас Цахим мөнгөний зөвшөөрлийг хугацаагүй олгов.




7.0 тэрбум төгрөгийн хаалттай бондыг амжилттай эргэн төлөв.



Цахим зээлийн үйлчилгээг шинэчилж, зээлийн гэрээг Ард Аппаар баталгаажуулдаг болов.

# Онцлох үйл явдал - Ард Кредит




1.0 тэрбум төгрөгийн  
**НОГДОЛ АШИГ** хуваарилав.

8.9 тэрбум төгрөгийн  
**НЭМЭЛТ хувьцаа** гаргав.

Онлайн зээлийн шинэчилсэн  
нөхцөл нэвтрүүлэв.

# Онцлох үйл явдал - Ард Кредит



Автомашинны зээлийн хүсэлтийг Ард Аппаар шийдвэрлэдэг болов.



Да Хүрээ Phygital салбар нээв.



Мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 магадлах аудитын баталгаажуулалтын гэрчилгээ авав.


# Онцлох үйл явдал - Ард Кредит



Дэлхийн **Бичил Санхүүгийн**  
26 дахь хуралд оролцов.



**ТОП 20** индекст 5 дахь  
жилдээ дараалан багтав.



# Онцлох үйл явдал - Ард Кредит

## Pick n Pay by ARD

# +500

Мерчант



Урамшуулал

BISHRELT  
— BEAUTY —

GOBI  
MONGOLIAN CASHMERE

technozone  
FIRST TO DELIVER



shoppu баяр нэмнэ

FERRAGAMO

ISAIA  
NAPOLI

QUINTO  
CONCEPT STORE

ame  
CONCEPT STORE

MONTBLANC



BOSS  
HUGO BOSS


AIRMARKET



# Онцлох үйл явдал - Ард АКТИВ

Салбартаа **тэргүүлэх** 2 хоршооны нэг болов.


▲ Нийт хөрөнгө - 45%  
— Салбарын нийт хөрөнгө - 32%



▲ Зээл – 48%




▲ Хадгаламж – 57%  
— Салбарын хадгаламж - 40%



▲ ХНХ




▲ Цэвэр ашиг – 32%



2024 оны 6 сарын 30-ны байдлаар, өмнөх оны мөн үеэс

# Онцлох үйл явдал - Ард Лизинг



Түмэн Ардын гишүүдэд борлуулалтын урамшуулал олгов.



Төвийн бүсийн аймгуудын Ард Даатгал, Монгол шуудан ХК-тай хамтын ажиллагаа эхлүүлэв.

## Даатгалын кластерын гүйцэтгэл



Цахим даатгал

**24/7**



Даатгал хийлгэхэд

**5 минут**



Хамгийн хялбар

**Нөхөн төлбөр**



Автомат

**Тэтгэврийн  
хуримтлал**

▲ 30.2%

Нийт хөрөнгө

**₮97.5 тэрбум**

▲ 26.2%

Эздийн өмч

**₮ 20.0 тэрбум**

▲ 44.4%

Нийт Орлого

**₮27.5 тэрбум**

▲ 26.0%

Хөрөнгө оруулалтын багц

**₮71.5 тэрбум**



Нийт даатгуулагчийн тоо

**246,408**

Эмэгтэй  
**32%**

Эрэгтэй  
**68%**



Нийт хуримтлал эзэмшигчийн тоо

**141,398**

Эмэгтэй  
**58%**

Эрэгтэй  
**42%**

2024 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар, өмнөх оны мөн үеэс

# Онцлох үйл явдал - Ард Даатгал



Олон улсын мэргэжилтнүүдтэй хамтарсан хөрөнгийн эрсдэлийн үнэлгээ хийж, сургалт хийв.

Ард Даатгал 2023 оны цэвэр ашгийн **33.8%** буюу **750 сая** төгрөгийн ногдол ашиг хуваарилах тов зарлагдав.

Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүд зах зээлд **нэвтрүүлэн** ажиллаж байна.

# Онцлох үйл явдал - Ардын Тэтгэврийн Сан

120+

Нийт хамтрагч байгууллага

1800+

Нийт хуримтлал эзэмшиж буй ажилтнууд

Нэгдүгээр хагас жилд шинээр нэмэгдсэн байгууллагын тоон мэдээлэл

143+

Байгууллагын сургалт

10+

Нийт шинээр нэмэгдсэн хамтрагч байгууллага

122+

Нийт шинээр нэмэгдсэн хамтрагч байгууллагын ажилтнуудын тоо



Техник Технологийн  
Дээд сургууль



МОНГОЛ  
КООСЭН



МОНГОЛ  
ШУУДАН



ШИННИЙГ ЭРЭЛХИЙЛНЭ



ТЭС ПЕТРОЛИУМ ТӨ



ЖИ ЖИ ГРОСЕРИС ХХК



ГУРВАН ГАЛ  
НЭГДСЭН ЭМНЭЛЭГ



ХАНЛОР



МОНГОЛЫН  
УРПАГИАН  
ЗӨВЛӨЛ



СМАРТ БРОКЕРС  
ДААТГАЛЫН НЭГДСЭН ТӨВ



FIRST TO DELIVER



TAVAN ORD  
WE SAVE LIVES



МУЛТИПАК



FoodSpot  
Will taste in the mind

# Хөрөнгө оруулалтын банкны кластерын **гүйцэтгэл**



Цахим арилжаа

**24/7**



Автомат

**Хуримтлал**



Багц бүрдүүлэх

**Боломж**



Ухаалаг хөрөнгийн

**Удирдлага**

▲ 9.66%

Нийт хөрөнгө

**₮12.7 тэрбум**

▼ -5.75%

Эздийн өмч

**₮7.9 тэрбум**

▼ -6.59%

Санхүүжилт

**₮23.4 тэрбум**

▼ -6.17%

Удирдаж буй хөрөнгө

**₮8.3 тэрбум**



Нийт арилжаа

**₮30.9 тэрбум**

Ард апп

**32%**

Брокер

**68%**



Нийт харилцагчдын тоо

**171,157**

Эмэгтэй

**61%**

Эрэгтэй

**39%**


2024 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар, өмнөх оны мөн үеэс

Хүчтэй. Хамтдаа.

# Онцлох үйл явдал - Ард Секюритиз



Хиймэл оюун ухаанд суурилсан баялгийн удирдлагын платформ болох **Investbanq**-тай хамтран ажиллах үйл ажиллагааны санамж бичиг байгуулав




Уул уурхайн биржийн брокерийн арилжааны **тусгай зөвшөөрөл** авч, үйл ажиллагааг эхлүүлэв




Экспоненшиал партнерстай гадаад хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэхээр хамтран ажиллах **үйл ажиллагааны санамж бичиг** байгуулав

# Онцлох үйл явдал - Ард Менежмент



ҮНДЭСНИЙ  
ХУВЬЧЛАЛЫН  
САН

## Хөрөнгө оруулалтын бүтэц



Дотоод хувьцаа

26 ХУВЬЦАА

Гадаад хувьцаа

6 ХУВЬЦАА

Үнэт цаас

БОНД

Хадгаламж

ХАДГАЛАМЖ

### Багцад эзлэх хувь

Дундаж

Өндөр

3.2%

8.7%

0.9%

1.5%

2.1%

2.1%

3.1%

3.1%

# Онцлох үйл явдал - Ард Менежмент




ҮНДЭСНИЙ  
ХУВЬЧЛАЛЫН  
САН

Хувьцааны багц

## Технологи



## Уул уурхай



## Тогтмол хэрэглээ



## Санхүү



## Тогтмол бус хэрэглээ



Монголын  
Хөрөнгийн Бирж



Ард Кредит ББСБ



ЛэндМН ББСБ



Ард Санхүүгийн  
Нэгдэл





# Онцлох үйл явдал - Ард Менежмент



## Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ (NAV)



16 ХУВЬЦАА

4 ХБҮЦ

2 ХАДГАЛАМЖ

Хүчтэй, Хамтдаа.



# Онцлох үйл явдал - Ард Менежмент



Хүчтэй. Хамтдаа.

ЛэндМН ББСБ



Таван Толгой




Хас банк




Ард Санхүүгийн Нэгдэл



Ард Кредит ББСБ



# Засаглалын бүтэц



## ХАМГААЛАЛТЫН ГУРВАН ДАВХАРГА

### Гуравдахь давхарга

Дотоод аудитор

Дотоод аудит нь бие даасан эрсдэлийн үнэлгээ болон компанийн засаглал, баталгаажуулалт, зөвлөмж гарган ажиллах

### Хоёрдахь давхарга

Хяналтын хэлтэсүүд

Санхүүгийн удирдлага, Мэдээллийн аюулгүй байдал, Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг цаг алдалгүй ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэх

### Эхний давхарга

Бүх хэлтэс, ажиллагсад

Өдөр тутмын үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлэх

# Төлөөлөн Удирдах Зөвлөл



Чулууны **Ганхуяг**  
ТУЗ-ийн Дарга,  
Ард Санхүүгийн Нэгдэл

## Ердийн Гишүүн



**Бруно** Рашле  
Дэд Дарга,  
Шродер Капитал Холдинг



Авирын **Сүхдорж**  
Үүсгэн байгуулагч,  
ГрэйпСити Монгол



Одончимэдийн **Одбаяр**  
Гүйцэтгэх Захирал,  
Мон-Интернэшнл

## Хараат Бус Гишүүн



**Арно** Вентура  
Үүсгэн байгуулагч,  
Баобоб Групп



Чулууны **Мөнхбат**  
Дэд ерөнхийлөгч,  
Саусгоби Ресурс Лимитед




**Михаил** Зелдович  
Хяналтын зөвлөлийн дарга,  
Кокуун капитал



Мөнх-Очирын **Сэргэлэн**  
Захирал,  
ТТДС



**Роланд** Нэш  
Үүсгэн байгуулагч түнш,  
Ви Пи И Капитал



# Удирдлагын баг

## Ард Санхүүгийн Нэгдэл ХК



Батбилэгийн **Золбоо**  
Гүйцэтгэх Захирал



Мөнхбат **Мөнх-Эрдэнэ**  
Дотоод Аудитор



Хүрэлбаатарын **Билгүүн**  
Санхүү Эрхэлсэн Захирал



Чулууны **Алтан-Өлзий**  
Дата Судалгаа  
Эрхэлсэн Захирал



Батбаярын **Ганчимэг**  
Хамтын Ажиллагаа, Олон  
Нийттэй Харилцах  
Газрын Захирал



Буяндэлгэрийн **Уянга**  
Хүний Нөөц Хариуцсан  
Захирал



Сүхчулууны **Нямгэрэл**  
Хууль, Эрх Зүй  
Хариуцсан Захирал

## Охин компаниудын удирдлагууд



Гүррагчаагийн **Сүхбаатар**  
Ард Кредит



Даваажавын **Мөнх-Од**  
Ард Лизинг



Гүнрэгийн **Долгорсүрэн**  
Ард Секюритиз



Галнямын **Уянга**  
Ард Пропертиз



Ганхуягийн **Билгүүн**  
Ард Актив



Намдалдагвны **Эрдэнэтулга**  
Ард Даатгал




Чадраабал **Даваасамбуу**  
Ард Менежмент



Цэнд-Аюушийн **Солонго**  
Ард Суппорт



Цэрэнжавын **Тайшир**  
Ардын Тэтгэврийн  
Данс



# Тусдаа орлогын тайлан (аудитлагдаагүй)

(сая төгрөг)	2023Q2	2023	2024Q2	2024Q2 (B)	Жилийн өсөлт	Оны эхнээс
Менежментийн орлого	2,002	1,886	1,681.7	1,614.0	(16%)	(11%)
Хөрөнгө оруулалтын орлого	0	5,969	4,232.7			(29%)
Ногдол ашгийн орлого	0	46	452.3	878.1		883%
Хүүгийн орлого	344	1,067	502.7	266.5	46%	(53%)
<b>Нийт хөрөнгө оруулалтын орлого</b>	<b>2,346</b>	<b>8,968</b>	<b>6,869.4</b>	<b>2,758.6</b>	<b>193%</b>	<b>(23%)</b>
Бусад орлого	401	3,024	137.9		(66%)	(95%)
<b>Нийт орлого</b>	<b>2,747</b>	<b>11,992</b>	<b>7,007.3</b>	<b>2,758.6</b>	<b>155%</b>	<b>(42%)</b>
Борлуулалт, маркетингийн зардал	1,458	1,193	22.0	190.0	(98%)	(98%)
Үйл ажиллагааны зардал	3,717	7,776	2,872.7	3,632.7	(23%)	(63%)
Санхүүгийн зардал	1,321	3,641	2,023.0	1,593.9	53%	(44%)
Бусад зардал	218	396	351.0		61%	(11%)
<b>Нийт зардал</b>	<b>6,714</b>	<b>13,006</b>	<b>5,268.7</b>	<b>5,416.6</b>	<b>(22%)</b>	<b>(59%)</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	5	102	(6.7)		34%	(107%)
Бусад олз (гарз)		1,497	(1.8)			(100%)
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(3,962)</b>	<b>585</b>	<b>1,730.1</b>	<b>(2,658.0)</b>	<b>(56%)</b>	<b>196%</b>
Орлогын албан татварын зардал	38	470	186.2		390%	(60%)
<b>Цэвэр ашиг</b>	<b>(4,000)</b>	<b>115</b>	<b>1,543.9</b>	<b>(2,658.0)</b>	<b>(61%)</b>	<b>1,247%</b>
Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз (гарз)	(10,514)	(19,466)	(8,677.9)		(17%)	55%
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>(14,514)</b>	<b>(19,351)</b>	<b>(7,134.0)</b>	<b>(2,658.0)</b>	<b>(51%)</b>	<b>63%</b>

# Тусдаа санхүүгийн тайлан (аудитлагдаагүй)

(сая төгрөг)	2023 Q2	2023	2024 Q2	2024 Q2 (B)	Жилийн өсөлт	Оны эхнээс
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3	329	2	976	(39%)	(99%)
Дансны болон бусад авлага	23,214	53,461	49,821	21,670	115%	(7%)
Бусад санхүүгийн хөрөнгө	691	705	326	1,035	(53%)	(54%)
Бараа материал	104	104	114		9%	9%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,410	10,939	3,707	5,674	(16%)	(66%)
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>	<b>28,423</b>	<b>65,539</b>	<b>53,970</b>	<b>29,355</b>	<b>90%</b>	<b>(18%)</b>
Үндсэн хөрөнгө	536	429	326	405	(39%)	(24%)
Виртуал хөрөнгө	11,072	88	178		(98%)	102%
Биет бус хөрөнгө	180	262	2,291	151	1,173%	774%
Ашиглах эрхтэй хөрөнгө	854	460	66		(92%)	(86%)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	88,983	82,163	77,393	95,875	(13%)	(6%)
<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>101,625</b>	<b>83,403</b>	<b>80,254</b>	<b>96,431</b>	<b>(21%)</b>	<b>(4%)</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>130,048</b>	<b>148,942</b>	<b>134,224</b>	<b>125,787</b>	<b>3%</b>	<b>(10%)</b>
Дансны болон бусад өглөг	14,060	21,835	27,525	17,592	96%	26%
Богино хугацаат зээл	2,619	6,853	3,154	4,473	20%	(54%)
Богино хугацаат бондын өр төлбөр	1,020	370	370	370	(64%)	0%
Богино хугацаат түрээсийн өглөг	451	608	140		(69%)	(77%)
Урьдчилж орсон орлого	11,552	19,408	9,768	11,266	(15%)	(50%)
<b>Нийт богино хугацаат өр төлбөр</b>	<b>29,702</b>	<b>49,074</b>	<b>40,957</b>	<b>33,701</b>	<b>38%</b>	<b>(17%)</b>
Урт хугацаат түрээсийн өглөг	608	0	0		(100%)	
Урт хугацаат зээл	5,621	12,193	13,585	12,964	142%	11%
Хойшлогдсон татварын өр	5,019	3,413	2,330	3,321	(54%)	(32%)
<b>Нийт урт хугацаат өр төлбөр</b>	<b>11,248</b>	<b>15,606</b>	<b>15,915</b>	<b>16,285</b>	<b>41%</b>	<b>2%</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>40,950</b>	<b>64,680</b>	<b>56,872</b>	<b>49,986</b>	<b>39%</b>	<b>(12%)</b>
Өмч-хувьцаат	28,614	28,614	28,614	28,614	0%	0%
Нэмж төлөгдсөн капитал	2,928	2,928	2,928	2,928	0%	0%
Дахин үнэлгээний нөөц	42,279	28,362	19,684	27,000	(53%)	(31%)
Эздийн өмчийн бусад хэсэг	14	14	14	14	(1%)	0%
Хуримтлагдсан ашиг	15,264	24,344	26,112	17,245	71%	7%
<b>Эздийн өмч</b>	<b>89,099</b>	<b>84,262</b>	<b>77,352</b>	<b>75,801</b>	<b>(13%)</b>	<b>(8%)</b>

# MSE: Хувьцаа Эзэмшигчдийн Бүтэц

#	Хувьцаа эзэмшигч	2023	%	2024 Q2	%	Өөрчлөлт	Өөрчлөлтийн хувь
1	Эйч Ви Эл Эл ХХК	2,775,406	9.70%	3,045,406	10.64%	270,000	0.94%
2	Ардын Тэтгэврийн Данс ХХК	2,517,778	8.80%	2,771,433	9.69%	253,655	0.89%
3	Бруно Рашле	2,109,997	7.37%	2,109,997	7.37%	0	0.00%
4	А.Сүхдорж	1,944,990	6.80%	1,944,990	6.80%	0	0.00%
5	Ч.Ганхуяг	1,590,466	5.56%	1,591,006	5.56%	540	0.00%
6	Г.Уянга	1,389,754	4.86%	1,390,470	4.86%	716	0.00%
7	Ард Венчурс ХХК	1,429,244	4.99%	1,149,135	4.02%	(280,109)	(0.98%)
8	Голомт Кастодиан	900,000	3.15%	900,000	3.15%	0	0.00%
	ARDT	900,000	3.15%	900,000	3.15%	0	0.00%
9	Ард Лизинг ХХК	680,976	2.38%	812,888	2.84%	131,912	0.46%
10	С.Гэрэлтуяа	455,935	1.59%	455,935	1.59%	0	0.00%
11	Ронок Лимитед	443,816	1.55%	443,816	1.55%	0	0.00%
12	С.Оргил	390,937	1.37%	390,937	1.37%	0	0.00%
13	Ард Кредит ББСБ	525,489	1.84%	381,086	1.33%	(144,403)	(0.50%)
14	Ард Секюритиз ҮЦК	400,988	1.40%	370,706	1.30%	(30,282)	(0.11%)
15	Г.Бат-Эрдэнэ	351,268	1.23%	351,268	1.23%	0	0.00%
16	Н.Мөнхнасан	344,311	1.20%	342,973	1.20%	(1,338)	(0.00%)
17	Масик Энтерпрайзес	321,078	1.12%	321,078	1.12%	0	0.00%
18	Х.Батхишиг	319,346	1.12%	319,346	1.12%	0	0.00%
19	Ард Даатгал	253,265	0.89%	253,265	0.89%	0	0.00%
20	Д.Отгонбаяр	233,303	0.82%	233,303	0.82%	0	0.00%
<b>Топ 20</b>		<b>19,378,347</b>	<b>67.72%</b>	<b>19,579,038</b>	<b>68.42%</b>	<b>200,691</b>	<b>0.70%</b>
Бусад		9,235,916	32.28%	9,035,225	31.58%	(200,691)	(0.70%)
<b>Эргэлтэд буй хувьцаа</b>		<b>28,614,263</b>	<b>100%</b>	<b>28,614,263</b>	<b>100%</b>	<b>0</b>	<b>0.00%</b>
Халаасны хувьцаа							
<b>Нийт гаргасан хувьцаа</b>		<b>28,614,263</b>					0.00%
Хувьцаа эзэмшигчид		19,069		18,661		(408)	
ARDT эзэмшигчид		3,061		3,077		16	
ADT эзэмшигчид (хүүхдүүд)		55,166		58,431		3,265	


# MSE: Хувьцааны арилжаа

МХБ: ADB хувьцааны арилжаа




<b>Нээлт</b>	₮2,789.00
<b>52 долоо хоног</b>	₮2,671 - ₮3,650
<b>Хаалт (2024/06/30)</b>	₮2,892.00
<b>33Ү</b>	₮86.47 тэрбум

(тэрбум төгрөг)	2021	2022	2023
<b>Хувьцааны эргэц</b>	33.0%	13.0%	9.2%
<b>Арилжааны дүн</b>	72.2	23.1	8.7



# Хувьцааны арилжаа



Ticker	2024Q2 (хагас жилээр)		52 долоо хоног		2024Q2 (хагас жилээр)		52 долоо хоног		2024 оны 6 сарын 30-ны байдлаар	
	Дээд	Доод	Дээд	Доод	Нийт арилжааны дүн	Эргэц %	Нийт арилжааны дүн	Эргэц %	Хаалтын ханш	Зах зээлийн үнэлгээ
AARD	3,448.0	2,731.0	3,576.0	2,731.0	2.53B	2.90%	8.47B	9.43%	2,987	85.47B
AIC	839.8	670.1	950.0	670.1	0.6B	3.38%	1.37B	7.16%	690.48	17.26B
ADB	122.0	101.0	139.0	97.0	0.89B	2.30%	2.59B	6.22%	104.23	37.94B
MNP	922.0	600.0	975.0	600.0	0.86B	1.06%	1.47B	1.79%	709	70.61B
TNGR	9,890.0	5,900.0	12,000.0	5,900.0	0.51B	1.21%	0.97B	2.08%	6,010	36.06B
CNF	77,800.0	42,080.0	80,000.0	42,080.0	0.52B	8.97%	1.4B	22.37%	69,000	7.81B
ХОС	105.0	91.1	115.9	91.1	0.14B	2.96%	0.44B	8.78%	102.93	5.15B
MOST	54.0	40.0	55.7	40.0	0.93	4.87%	1.55	7.75%	48	23.33B

\*Хамаарал бүхий нээлттэй компаниуд



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ  
**ҮНДЭСТЭН**

**Анхаарал хандуулсанд баярлалаа**

**ARD** САНХҮҮГИЙН  
НЭГДЭЛ

**ARD** | ДААТГАЛ  
SINCE 1994

**ARD** КРЕДИТ  
ББСБ

**ARD** АКТИВ  
ХЗХ

**ARD** БИТ



ҮНДЭСНИЙ  
ХУВЬЧЛАЛЫН  
САН

**ARD** СЕКЮРИТИЗ  
ҮЦК

**ARD** ТЭТГЭВРИЙН  
САН

**ARD** МЕНЕЖМЕНТ  
КОМПАНИ

**ARD** ЛИЗИНГ  
КОМПАНИ



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ  
ҮНДЭСТЭН  
БАЯЛГИЙН САН

**idax**

Хүчтэй. Хамтдаа.